



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/35/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	5
3.4. Материаллаг байдал	6
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	7
3.7. Шилэн дансны мэдээлэл	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт	8
Залруулсан алдаа	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	8
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	9
4. Менежментийн захидал	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	12

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.08.25 № 73

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН 20-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Р.АЛТАНТУЯА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг 20-р цэцэрлэгийн эрхлэгч Р.Алтантуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийг орлого авахдаа НХМаягт ҮХ-1 маягтаар орлого авч баримтжуулан, тайлагнах, шаардах хуудсыг дугаарлаж, тухайн материал хүссэн хүнээр бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж бүрэн гүйцэд хөтөлж байх, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж, мэдээлж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 21-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 309,186.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,091.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 566,768.6 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 5,667.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,832.4 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	66,781.1	67,830.3	1,049.2
Үндсэн хөрөнгө	1,531,871.7	1,524,930.0	-6,941.7
Нийт хөрөнгө	1,598,652.8	1,592,820.4	-5,832.4
Өр төлбөр	2,056.3		-2,056.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	379,346.2	379,346.2	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,598,652.8	1,592,820.4	-5,832.4

Мөнгөн хөрөнгө, авлага болон урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 67,830.3 мянган төгрөг болж 1,049.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Энэ нь төсвийн хөрөнгөөр 2,328.9 мянган төгрөгийн бараа материал, Баян-өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 12 нэр төрлийн 116 ширхэг, 819.9 мянган төгрөгийн үнэтэй модон тоглоом тус бүрийг тусгай зориулалтын материал дансанд орлого авч үлдэгдлээр үлдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,524,930.0 мянган төгрөг болж тайлант оны 6,941.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна. Аймгийн орон нутгийн өмчийн газраас орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 25,700.0 мянган төгрөгийн цэвэр болон бохир усны шугам, Боловсрол шинжлэх ухааны яамнаас нэг бүр нь 1,749.5 мянган төгрөгийн үнэтэй 3 ширхэг зөөврийн компьютерийг тус бүр шилжүүлэн авч орлогод бүртгэсэн байна.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй, өмнөх оны 2,056.3 мянган төгрөгийн өрийг төлж, өр төлбөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 379,346.2 мянган төгрөг өөрчлөлт гараагүй байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 665,507.0 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 570,544.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин 32,308.9 мянган төгрөг, НДШ 4,115.4 мянган төгрөгөөр зардлууд өссөн байна. Энэ нь МУ-ын засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 сараас цалин нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс нийт зарлагыг 648,053.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 37,617.6 мянган төгрөгөөр бууруулж нийт зардлыг 610,435.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Оны сүүлээр ковид-19 цар тахалтай холбоотой хэмнэгдсэн 84,227.7 мянган төгрөгийг зардлыг хасч, төсвийг 526,208.0 мянган төгрөгөөр өөрчлөн баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 526,208.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 494,340.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 31,867.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 494,340.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 31,867.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 512,981.1 мянган төгрөгийг зарцуулж, 13,126.9 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 13,126.9 мянган төгрөг буюу 2.5 хувьтай байгаа нь тогтмол зардлыг 9,824.2 мянган төгрөг, ном хэвлэлийн зардлыг 100.8 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардлыг 2,337.5 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 48.0 мянган төгрөг, томилолтын зардал 164.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 141.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 510.7 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш 501,790.2 мянган төгрөгийн 12 орлогын, 53,045.6 мянган төгрөгийн худалдан авалтын 42 гүйлгээг мэдээллэсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1		1				
Албан шаардлага							
Зөвлөмж	5		5				
Нийт дүн	6		6				

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,441.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,629.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 381.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,430.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Орлого үр дүнгийн тайланд урамшуулалт цалингаас 11 төгрөгийг НДШ-ийн зардалд, бараа материалын тайланд БСГ-т шилжүүлсэн 1,629.8 мянган төгрөгийн хүнсний материалыг өөрийн зардлаар тус бүр бүртгэснийг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 4,812.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 381.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,430.9 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 3 албан хаагчдад 381.2 мянган төгрөгийн урамшуулалт цалинг илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 4 албан хаагчдад 307.9 мянган төгрөгийн урамшуулалт цалинг дутуу олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Нийт ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 20-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.12.15-ны өдрийн 51 дүгээр тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 117.8 мянган төгрөг буюу нийт 4,123.0 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Цалин, бараа материалыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл, бодлогын үйл ажиллагаа

1.1. Илрүүлэлт:

Дээд шатны байгууллагаас ирсэн 5,248.5 мянган төгрөгийн зөөврийн компьютерийг орлого авахдаа НХМаягт ҮХ-1 маягтаар хөтлөөгүй, бараа материалын тайланд дагалдаж ирсэн зарлагын падаанаар орлогод авсан, шаардах хуудсыг дугаарлаагүй, нярав материалын шаардахыг бичиж дарга, нягтлангаар хянуулдаггүй шууд олгодог байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” заалтуудыг хэрэгжүүлж, үндсэн хөрөнгийн тайланд ҮХ-1 маягтаар орлого авч баримтжуулан, тайлагнах, шаардах хуудсыг дугаарлаж, тухайн материал хүссэн хүнээр бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж бүрэн гүйцэд хөтөлж байх.

Хууль эрх зүйн орчинтой холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Шилэн дансны мэдээллийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

2.2 Эрсдэл:

Хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д “Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана” гэсэн заалтыг хэрэгжүүлж, дээрх мэдэгдлийг гаргаж шилэн дансны цахим сайтад тогтоосон хугацаанд мэдээллийг бүрэн мэдээлж байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Орхон аймгийн 20-р цэцэрлэгт өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.22-ны 16 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР



АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

		Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит		
				САГ-2021/35/СТА-ТШЗ
Огноо: 2021	Аудитын нэр:	Аудитын код:		

Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал					
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Дээд шатны байгууллагаас ирсэн 5,248.5 мянган төгрөгийн зөөврийн компьютерийг орлого авахдаа НХМаягт ҮХ-1 маягтаар хөтлөөгүй, бараа материалын тайланд дагалдаж ирсэн зарлагын падаанаар орлогод авсан, шаардах хуудсыг дугаарлаагүй, нярав материалын шаардахыг бичиж дарга, нягтлангаар хянуулдаггүй шууд олгодог байна.		Зөвлөмж	Эрхлэгч, нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул
2	Шилэн дансны мэдээлэлийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж мэдээлээгүй, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.		Зөвлөмж	Эрхлэгч, нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул
3	Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 3 албан хаагчдад 381.2 мянган төгрөгийн урамшуулалт цалин илүү олгосон байна.	381.2	Төлбөрийн акт	Эрхлэгч, нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул
3	Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 4 албан хаагчдад 307.8 мянган төгрөгийн урамшуулалт цалин дутуу олгосон байна.	307.9	Албан шаардлага	Эрхлэгч, нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул
4	Нийт ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 20-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.12.15-ны өдрийн 51 дүгээр тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү	4,123.0	Албан шаардлага	Эрхлэгч, нягтлан бодогч	Р.Алтантуяа А.Алтанзул

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

117.8 мянган төгрөг буюу нийт 4,123.0 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.				
ДҮН	4,812.1			

Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

117.8 мянган төгрөг буюу нийт 4,123.0 мянган төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.				
ДҮН	4,812.1			

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР

АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ

[Signature]

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 77/77 004-809/35/СТ-ТЦ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийт ажилтнуудад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосноос гадна 20-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.12.15-ны өдрийн 51 дүгээр тушаалаар цалингийн зардлын хэмнэлтээс бүх ажилтнуудад тэнцүү 117,800 төгрөг буюу нийт 4,123,000 төгрөг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Төрийн албаны тухай хуулийн 51.2-д "Энэ хуулийн 51.1.1-д заасан шагнал олгох, 51.1.3-т заасан шагналд тодорхойлох болон 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар, ... батална", 57.8-д "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсний доод хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно" гэсэн заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.4, 4.5 дахь заалт, 2018 оны 382-р тогтоолын 2-д "Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар

тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Холбогдох хууль, тогтоол, журамд үл нийцсэн тушаал гаргаж төсвийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн эрхлэгч Р.Алтантуяа, нягтлан бодогч А.Алтанзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:.....Б.ЭРДЭНЭ

АУДИТОР:.....О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 08 сарын 25- өдөр

Дугаар 85/85 ОРА-2021/35/ СТА-ТШ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 4 албан хаагчдад 307.9 мянган төгрөг дутуу олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтууд, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-тай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалин урамшууллыг буруу тооцоолж олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн эрхлэгч Р.Алтантуяа, нягтлан бодогч А.Алтанзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР.....

Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.....

Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....

О.ГАНТУЯА



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 46/46 ОД-2021/52/СТ-ТШ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2020.03.23-ны өдрийн 04 дүгээр тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо 3 албан хаагчдад 381.2 мянган төгрөг илүү, олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтууд, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3-р хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-тай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 20-р цэцэрлэгийн цалин илүү олгосон 381.2 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Орхон аймгийн 20-р цэцэрлэгийн эрхлэгч Р.Алтантуяа, нягтлан бодогч А.Алтанзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..... О.ГАНТУЯА

¹ Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7955